

Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр Телевизүүдийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал (2024 оны хагас жил)

Харилцаа холбооны зохицуулах хорооноос хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр телевизүүдийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн 2024 оны хагас жилийн тайланг нэгтгэн мэдээллэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевиз нь өөрийн хөтөлбөрийн нэвтрүүлэх мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттайгаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг.

Тус Хорооноос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.4-т заасан хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлгийн хувь хэмжээг тодорхойлох чиг үүргийн дагуу Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан редакцын бодлогын хүрээнд төлөвлөж төлөвлөгөөний дагуу гаргах үүргийг хүлээлгэсэн болно. Энэ нь дохионы хэлний хэлмэрчийн олдоц хязгаарлагдмал байдлыг харгалзан шат дараатай авч буй арга хэмжээний нэг юм.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон хөтөлбөртөө цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлэгүүд тусган нэвтрүүлдэг арилжааны 26, нийт 47 телевиз дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээж байна. Харин Монгол Улсад хамрах хүрээтэй боловч спорт, кино, теле-худалдаа зэрэг төрөлжсөн хөтөлбөртэй, хөтөлбөрт нь мэдээ, мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг байхгүй 13 арилжааны телевизийн хувьд тул дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээлгээгүй болно.

Энэхүү тайлангаар телевизүүдийн хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн хяналт, мониторингийн дүнгээс телевизүүд мэдээ мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэл, хадмал тайлбартай хэрхэн нэвтрүүлсэн талаарх дүн мэдээг нэгтгэн гаргав.

2024 оны хагас жилийн байдлаар ҮОНРТ-ийн 5 телевиз, өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, Монгол Улсад хамрах хүрээтэй 23 телевиз мөн үүрэг хүлээгээгүй боловч телевизийн редакцын хүрээнд 6 телевиз буюу нийт 52 телевизээр 5165 цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна. Нийт цагийн 75.53%-д буюу 28 телевизээр мэдээ, мэдээлэл, 6%-д буюу 16 телевизээр танин мэдэхүйн нэвтрүүлэг, харин 1.96%-д нь (7 телевизээр) хүүхдийн нэвтрүүлгийг тус тус дохионы хэлтэй нэвтрүүлжээ. Нийт 46 телевиз 1223 цагийн хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол нийт цагийн 43%-д (43 телевизээр) мэдээ, мэдээлэл 47.64%-д (16 телевизээр) танин мэдэхүйн нэвтрүүлэг, 5.83%-д хүүхдийн нэвтрүүлгийг тус тус нэвтрүүлсэн байна.

**2024 оны эхний хагас жилийн байдлаар 52 телевизээр нэвтрүүлсэн
дохионы хэл бичгэн тайлбартай нэвтрүүлгийн төрөл жанр /хувь/**



Тайлбар: Улаанбаатар хотод хамрах хүрээтэй, дохионы хэл, бичгэн тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээгээгүй арилжааны телевизүүдээс News channel, ТВ6, Цахим Монгол, Авто, М кино, С Channel телевиз нь дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна.

Телевизүүдээр нэвтрүүлсэн дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн тайлан

Мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн байдал

2024 оны хагас жилийн байдлаар

	Нэвтрүүлгийн төрөл	Телевизийн тоо	Нийт (цаг:мин:сек)	Нийт нэвтрүүлэгт эзлэх хувь
Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг	27	3768:44:58	75.53%
	Хүүхдийн нэвтрүүлэг	7	101:09:42	2.03%
	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	16	327:35:21	6.56%
	Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, соёл урлаг, спорт, зар сурталчилгаа, цэнгээнт,шашин)	Кино-4 Нийгэм улс төр-36 Соёл урлаг-4 Цэнгээнт-3 Шашин-2	968:04:19	19.40%
Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг	3	6:07:52	0.51%
	Хүүхдийн нэвтрүүлэг	6	71:19:19	5.89%
	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	16	582:41:18	48.08%
	Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, соёл урлаг, спорт, зар сурталчилгаа, цэнгээнт,шашин)	Нийгэм улс төр-43 Цэнгээнт-17 Шашин-2	562:52:48	46.45%


1. Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд

2024 оны хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
Үндэсний олон нийтийн телевиз		
1	MNB	184:30:50
2	MNB Монголын мэдээ	289:40:00
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
3	C1	141:27:21
4	NTV	234:04:16
5	SBN	14:25:37
6	UBS	256:23:05
7	Ийгл ньюс	185:10:31
8	Монгол HD	130:41:52
9	Сүлд	33:49:46
10	ТВ5	13:26:54
11	ТВ8	184:14:34
12	ТВ9	109:55:09
13	Тэнгэр ТВ	236:20:45
Арилжааны телевиз		
14	Channel 11	105:18:17
15	National times news	173:55:33
16	Volume Plus	9:14:42
17	Авто ТВ	95:25:47
18	Глобал ТВ	46:33:44
19	Лайв ТВ	171:38:47
20	Лайк ТВ	32:36:41
21	Мянгат малчин ТВ	67:36:50
22	Парламент	45:02:03
23	Суваг 1	123:18:55
24	Талын Монгол	80:01:45
25	ТВ2	241:44:15
26	ТВ6	109:03:17
27	Хөгжил ТВ	14:55:18
	Нийт цаг	3330:36:34
	Нийт дохионы хэлд харьцуулсан	76.58%

Дээрх нэр бүхий 27 телевиз өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрөө тодорхой хэмжээнд дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. Харин өргөн нэвтрүүлгийн 18 телевизээс 11 телевиз мэдээ, мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй бэлтгэн нэвтрүүлжээ.

Мэдээ, мэдээллийн хөтөлбөрийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлтэй нэвтрүүлгийн цагийг 2021-2023 оноор харьцуулан гаргахад телевизүүдийн өөрсдийн бүтээсэн дохионы хэлний цаг нь өссөн байгаа нь харагдаж байна.



2. Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд


2024 оны хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг
1	MNB Гэр бүл	1:20:22
2	MNB Монголын мэдээ	1:20:26
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
3	TB5	59:33:13
Арилжааны телевиз		
4	Movie Max	8:43:57
5	National times news	30:12:28
6	News Channel	4:32:03
7	Гандан ТВ	9:51:18
8	Их Засаг	18:22:35
9	Лайк ТВ	30:52:36
10	Парламент	0:09:36
11	Соён гэгээрүүлэгч	5:10:39
12	Суваг 7	8:33:08
13	Талын Монгол	2:05:49
14	TB6	27:56:18
15	Хөгжил ТВ	20:50:51
16	Цахим Монгол	2:12:47
	Нийт цаг	231:48:06
	Нийт дохионы хэлд харьцуулсан	5.33%

Дээрх телевизүүдээс Лайк телевиз эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмжийн нэвтрүүлгээ тогтмол дохионы хэлтэй нэвтрүүлж байгаа бол түүх, соёл, зан заншлын нэвтрүүлгийг Талын монгол, TV5 телевизүүд дохионы хэлтэй нэвтрүүлж байна.

Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2023 оноор доор харьцуулан харууллаа.

Танин мэдэхүйн нэвтрүүлэг



3. Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд


2024 оны хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн цаг
1	MNB	0:32:56
2	ETV	27:17:23
3	Стар ТВ	0:36:24
4	TB5	23:48:27
5	TB8	1:07:43
6	Dream	30:41:20
	Нийт цаг	88:49:14
	Нийт дохионы хэлд харьцуулсан	2.04%

2023 оны жилийн дүнгээр нийт 76 цагийн хүүхдийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол 2024 оны 1-5 сарын байдлаар 88 цаг хүүхдийн нэвтрүүлэгт дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. TB5 телевиз хүүхдийн нэвтрүүлэгтэй болж дохионы хэлтэй нэвтрүүлж эхэлсэн байна. Dream TV телевиз нь хүүхдэд зориулсан төрөлжсөн хөтөлбөртэй цорын ганц телевиз болохын хувьд тодорхой хэмжээнд дохионы хэлтэй нэвтрүүлж байгаа нь сайн үзүүлэлт юм.


Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2023 оноор доор харьцуулан гаргахад дохионы хэлтэй нэвтрүүлсэн тоо өссөн сайн үзүүлэлттэй байна.

Хүүхдийн нэвтрүүлэг




4. Бусад нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн байдал

Нийгэм, улс төрийн нэвтрүүлэг /ДХН/



Соёл, урлагийн нэвтрүүлэг



Телевизүүдээр нэвтрүүлсэн хадмал тайлбартай нэвтрүүлгийн тайлан

Нэвтрүүлгийн төрөл	Мэдээ	Нийгэм улс төр	Танин мэдэхүй	Хүүхэд	Бусад	Нийт цаг
Нийт цаг	4:58:04	455:16:17	445:29:54	51:38:51	34:11:00	1978:10:08
Нийт 40 телевизээр нэвтрүүлсэн хадмал тайлбартай нэвтрүүлэгт эзлэх хувь	0.50%	45.91%	44.93%	5.21%	3.45%	100%

Доорх хүснэгтэд нэвтрүүлгээ хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүдийн нийт цагийг нэвтрүүлгийн төрлөөр нь ангилан үзүүлж байна.

2024 оны хагас жилийн байдлаар

Телевизийн нэр	Хадмал тайлбартай нэвтрүүлгийн цаг	Нийт цаг	Нийт хадмал тайлбарт харьцуулсан хувь
Мэдээ мэдээлэл			
ТМ	0:27:11	4:58:04	0.50%
Малчин ТВ	4:30:53		
Хүүхдийн нэвтрүүлэг			
MNB	0:32:56	51:38:51	5.21%
C1	1:59:46		
Боловсрол суваг	0:06:38		
Dream TV	19:05:17		
National times news	12:04:21		
Мянгат Малчин ТВ	17:49:53		
Танин мэдэхүй			
Central ТВ	91:56:10	445:29:54	44.93%
Боловсрол суваг	148:58:18		
Ийгл ньюс	7:26:52		
Малчин ТВ	3:17:10		
Монгол HD	20:27:50		
ТВ5	65:24:05		

Тэнгэр ТВ	18:24:29		
Стар ТВ	66:15:47		
Мянгат Малчин ТВ	12:32:51		
Movie Max	8:43:57		
Авто ТВ	1:42:13		
National times news	0:05:01		
Нийгэм, улс төр			
Нийт-40 телевизээр	455:16:17		45.91%
Бусад			
Нийт-20 телевизээр	34:11:00		3.45%

оны 6-р сарын байдлаар нийт 46 телевиз 1223:10:37 цагийн хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

--oOo--